

**БНХАУ-ын цаг уурын байгууллагын сургалтын төвөөс зохион байгуулсан  
“Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийг бууруулахад богино хугацааны цаг  
уурын урьдчилан мэдээг хэрэглэх ба түүний хяналт”  
сэдэвт олон улсын цахим сургалтанд хамрагдсан товч тайлан**

2020.06.03

Нислэгийн цаг уурын төвийн мэдээлэл үйлчилгээний хэлтсийн Синоптик инженер Ш.Балжинням 2020 оны 05 сарын 18-наас 31-ны хооронд БНХАУ-ын цаг уурын байгууллагын сургалтын төвөөс зохион байгуулсан “Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийг бууруулахад богино хугацааны цаг уурын урьдчилан мэдээг хэрэглэх ба түүний хяналт” сэдэвт олон улсын цахим сургалтанд хамрагдсан.

Энэхүү олон улсын сургалт нь суралцагчдад цаг уурын гамшгаас урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлээр ойлголтыг нэмэгдүүлэх, цаг агаарын богино хугацааны урьдчилан мэдээлэх арга зүй, цаг уурын чиглэлээр техникийн солилцоо, цаашдын хамтын ажиллагааг сайжруулах зорилготой юм.

**Сургалтын агуулга:** Энэхүү цахим сургалт нь 3 хэсэгтэй явагдсан.

1-хэсэг нь “БНХАУ-ын цаг уурын байгууллагын танилцуулга, бүтэц, зохион байгуулалт”

2-р хэсэг нь “Уур амьсгалын хяналт, таамаглал, үнэлгээ”

- Хятадын улирлын урьдчилсан мэдээний аргууд
- ENSO-ийн олон талт байдал: онцлог, механизм, хяналт, таамаглал уур амьсгал, цаг агаарын эрс тэс нөхцөлийн хяналт
- Орон нутгийн хүчтэй аадар бороо орох эрчим ба түүний уур амьсгалд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний тоон загвар

3-р хэсэг нь “Гамшгийн эрсдэлийн менежмент ба уур амьсгалын үйлчилгээ”

- Өөрчлөгдөж байгаа цаг агаар болон эрс тэс уур амьсгалын эрсдэл
- Хятадын цаг уурын үйлчилгээ, хөгжлийн стратеги, GFCS ба CFCS-ийн танилцуулга
- Хятад дахь цаг уурын үйл ажиллагаа, үйлчилгээ

Багш нар: Дэлхийн цаг уурын байгууллагын албан хаагч, Хятадын цаг уурын хиймэл дагуулын үндэсний төвийн болон Хятадын цаг уурын байгууллагын сургалтын төвийн доктор багш нар оролцсон. Уг сургалтанд 75 орны 325 оролцогч хамрагдсан.

## **Дүгнэлт**

Энэхүү олон улсын цахим сургалтанд хамрагдсанаар хөгжиж буй болон бусад улс орнуудын цаг агаарыг урьдчилан мэдээлэгч болон бусад холбогдох салбарт ажиллаж буй цаг уурчидтай туршлага солилцож, мэдээлэл хуваалцсан. Энэ сургалтаар цаг уурын мэдээ ашиглан цаг агаарын гамшигт үзэгдлээс сэргийлэх, урьдчилан мэдээлэх, нөхцөл байдлыг шинжлэх талаар сүүлийн үеийн ололт, амжилт арга, техникийн талаар тодорхой ойлголт авч, мэдлэг дээшлүүлсэн.

Тайлан бичсэн:

НЦУТ-ийн синоптик инженер Ш.Балжинням